



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын сэдэв: "Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам эвсэлд нэгдэн орсон намуудад иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянаж баталгаажуулах" сэдэвт нийцлийн аудитын тайлан"

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу гүйцэтгэв.

**ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС АВСАН ХАНДИВ ХУУЛЬД
ЗААСАНТАЙ НИЙЦСЭН БАЙНА.**

Нэмэлт мэдээлэл, мэдээллийн эх сурвалж:



ДАРХАН-УУЛ АЙМАГ

2024 оны 8 дугаар сар

Аудитын зорилго, зорилтууд:

Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам эвсэлд нэгдэн орсон намуудад иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив хууль тогтоомжид нийцсэн эсэхэд нийцлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- АНСДИТХ-ын сонгуулийн тухай хууль зөрчиж хандив авсан байх
- АНСДИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 53.4 -т заасан хандивын мэдээллийн шаардлага хангаагүй хандивыг буцаан шилжүүлээгүй байх

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад аймаг, сумын ИТХ-ын сонгуульд Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж байгаа 18 нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын дансны хуулга, анхан шатны баримтыг хамрууллаа.

А.1 Иргэн, хуулийн этгээдээс авсан 129.5 сая төгрөгийн хандив хуульд заасантай нийцсэн байна.

1.1 Сонгуульд оролцох 18 нам, эвсэл хуульд заасан хугацаанд хандивын тайлангаа ирүүлсэн тул аудитын дүгнэлт гаргаж хүргүүлээ.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6-д (**Орон нутгийн Хурлын ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд, ээлжит бус, нөхөн болон дахин сонгуульд тухайн сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацаанд тухайн намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын төрийн аудитын байгууллагаар хянуулж, баталгаажуулсан тайлан**) заасны дагуу сонгуульд оролцох 18 нам, эвсэл иргэн, хуулийн этгээдээс авсан хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.7-д (**Нам, эвсэл нь орон нутгийн Хурлын ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө энэ хуулийн 25.3.6, 25.4.6-д заасан хандивын тайландаа дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ**) гэж заасан хугацаанд дүгнэлт гаргуулахаар Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Дээрх намууд хандивын тайлангаа Монгол Улсын Ерөнхий аудиторов 2024 оны А/49 дугаар тушаалаар баталсан маягтын дагуу гаргаж ирүүлсэн бөгөөд хуулиар хориглосон хандив хүлээн аваагүй тул хуульд нийцсэн тухай дүгнэлт гаргаж, аймгийн Сонгуулийн хороонд хуульд заасан хугацаанд хүргүүлсэн.

1.2 Иргэн, хуулийн этгээдээс авсан хандив нь хуульд нийцсэн байна.

Хандивын тайланг Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2024 оны А/49 дугаар тушаалаар батлагдсан зааврыг баримтлан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.1, 55.1.2, 55.1.3, 55.1.4, 55.1.5,

55.1.6, 55.1.7-д нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулсан болно.

Орон нутгийн 2024 оны ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд Дархан-Уул аймгийн "Ардчилсан нам" 124.1 сая, "ХҮН" нам 4.5 сая төгрөгийн хандив хүлээн авсан нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасантай нийцэж байна.

Б.2 Намуудын хүлээн авсан хандив хуульд заасан шаардлагад нийцсэн байна.

2.1 Дээрх 18 намаас хандив авсан Ардчилсан нам, ХҮН намын сонгуулийн хандивын тайланд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсэгт заасны дагуу сонгуулийн хандивын тайланд аудит хийж, дүгнэлт гаргалаа

Намуудын ирүүлсэн хандивын тайланг хянахад Улс төрийн намын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасан шаардлагад нийцсэн тул дүгнэлт гаргаж, холбогдох намуудад албан бичгээр хүргүүлэв.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Иргэн, хуулийн этгээдээс авсан 129.5 сая төгрөгийн хандив хуульд заасантай нийцсэн байна.
- Намуудын хүлээн авсан хандив хуульд заасан шаардлагад нийцсэн байна.